



ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДАД

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

20 20 0 2 . 18 № 03/496
танай _____-ны № _____-т

Тушаал хүргүүлэх тухай


Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн “Удирдамж батлах тухай” 04 дүгээр тушаалаар баталсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг манай 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/460 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албанаас батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг баталж, холбогдох шийдвэрүүдийг гаргасныг хавсралтаар хүргүүлж байна.

Иймд гамшгаас хамгаалах мэргэжлийн анги бүр шуурхай штабыг томилж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тодотголыг баталж, холбогдох шийдвэрүүдийг болон гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабтай өдөр тутам харьцаж мэдээллээр хангах албан тушаалтны нэр, албан тушаал, харилцах утасны дугаар, цахим хаягийг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөрт багтаан албан бичгээр, электрон хэлбэрээр erdenetsetseg@mmhi.gov.mn хаягаар яаралтай ирүүлнэ үү.

Хавсралт 7 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИШГИЙН ДАРГА БӨГӨӨД
ГАМШГААС ХАМГААЛАХ УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН УЛСЫН АЛБАНЫ ШТАБЫН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



d:\уухүя 2020\ям а4.docx

08 039'



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай


Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.3, 33.1.5 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабыг зохион байгуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын дарга Г.Нандинжаргалд даалгасугай.

2. Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабаас баталсан Төлөвлөгөөний дагуу зохион байгуулж буй арга хэмжээнүүдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж, штабаас өгсөн үүргийг заасан хугацаанд биелүүлж, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллахыг Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны мэргэжлийн ангийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Г.Ганхүү/-д зөвшөөрсүгэй.

САЙД



Д.СУМЬЯАБАЗАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А/21 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамжийн дагуу Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабаас зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штаб, мэргэжлийн нэгжүүдийг шуурхай зохион байгуулалтад оруулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүрд танилцуулж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга бөгөөд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын орлогч дарга /М.Баяраа/-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Г.Ганхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн Төрийн бичгийн даргын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн /27/ дугаар тушаалын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН УЛСЫН АЛБАНЫ ШТАБААС ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ХЭСЭГЧИЛСЭН БАЙДЛААР ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гамшгаас хамгаалах тухай хууль	Улсын онцгой комиссын даргын 2020.02.13-ны өдрийн 04 дүгээр тушаал	Хугацаа	Гамшгаас хамгаалах штаб	Овог, нэр	Албан тушаал
1	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны штабын хурлыг удирдаж, хурлаас гарах шийдвэрийн төслийг Албаны дарга болон Штабын даргад танилцуулж, шуурхай арга хэмжээг авах		2 дахь заалт	2020.02.14-2020.04.15	Штабын орлогч дарга	М.Баяраа	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
2	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албанаас Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг удирдлагаар, нэгжийн ангиудын бэлэн байдлын зөвлөмжөөр хангах		2 дахь заалт	2020.02.14-2020.04.15	Штабын орлогч дарга	М.Баяраа	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
3	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны Өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн мэдээ, тайланг 7 хоног тутамд Албаны дарга болон Штабын даргад танилцуулах		2 дахь заалт	2020.02.21-ний өдрөөс эхлэх	Штабын орлогч дарга	М.Баяраа	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
4	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллах хуваарийг батлуулж, штабын бүрэлдэхүүнд танилцуулах		2 дахь заалт	2020.02.17	Штабын орлогч дарга	М.Баяраа	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

5	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны 2020 оны төлөвлөгөө болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны гамшгаас хамгаалах 2020 оны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг удирдаж, ажлын хэсэгт ОБЕГ-аас заавар, аргачлалын зөвлөмжийг авч, төлөвлөгөөг батлуулах		Монгол Улсын Шадар сайдын 2018 оны "Заавар батлах тухай" 120 дугаар тушаал	2020.03.01-2020.04.15	Штабын орлогч дарга	М.Баяраа	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
6	Гамшгаас хамгаалах асуудлаарх хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах	33.1.3	1 дэх заалт	2020.02.14-2020.04.15		Штабын бүрэлдэхүүн	
7	Улсын онцгой комиссын даргын 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн "Удирдамж батлах тухай" 04 дүгээр тушаалыг салбарын байгууллагуудад хүргүүлэх.		2 дахь заалт	2020.02.14	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн Ахлах шинжээч
8	"Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тухай" Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны даргын тушаалыг гаргуулж, мэргэжлийн ангиудад хүргүүлэх		2 дахь заалт	2020.02.14	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн Ахлах шинжээч
9	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний төслийг боловсруулан штабын бүрэлдэхүүнд танилцуулж, Штабын даргаар батлуулж, нэгжийн ангиудад хүргүүлэх		2 дахь заалт	2020.02.17	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн Ахлах шинжээч
10	Удирдамжийн дагуу баталсан төлөвлөгөөний биелэлтийг харьяа байгууллагуудаас авч нэгтгэн штабын бүрэлдэхүүнд танилцуулж, ОБЕГ-т хүргүүлэн мэдээ, тайлангаар хангах			2020.02.21-нээс 7 хоног тутамд	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн Ахлах шинжээч

11	Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албаны 2020 оны төлөвлөгөө болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны гамшгаас хамгаалах 2020 оны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг байгуулах шийдвэрийг гаргуулж, ажлын хэсгийн ажлын явцын мэдээллээр удирдлагыг хангах		Монгол Улсын Шадар сайдын 2018 оны "Заавар батлах тухай" 120 дугаар тушаал	2020.02.17	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн Ахлах шинжээч
12	Салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгаж, хэрэгжилтийг хангуулах	33.1.2	1 дэх заалт	2020 он	Гамшиг осолтой тэмцэх асуудал хариуцсан ажилтан	Э.Батболд	УУХҮЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга
13	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг томилгоожуулж, гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах	33.1.5, 33.1.7, 33.1.10	4 дэх заалт	2020.02.17- 2020.02.20	Гамшиг осолтой тэмцэх асуудал хариуцсан ажилтан	Э.Батболд	УУХҮЯ-ны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын дарга
14	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд салбарын байгууллагуудыг эрсдлийн үеийн шинэ мэдээллээр хангаж ажиллах/УУХҮЯ-ны вейб сайтаар мэдээллийг түгээх/			2020.02.14- 2020.03.02	Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан	Б.Мөнхтөр	УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
15	Гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах	33.1.9	1 дэх заалт		Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан	Б.Мөнхтөр	УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
16	Салбарын байгууллагуудын эрсдэлийн үнэлгээг хийлгэх зөвлөмжөөр хангаж, эрсдлийн судалгааг хийж, эрсдлийг бууруулах үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг гаргаж штабын бүрэлдэхүүнд танилцуулах	33.1.12	1 дэх заалт		Эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан	Б.Мөнхтөр	УУХҮЯ-ны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
17	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Засгийн газар, Онцгой байдлын комиссоос гарсан аливаа шийдвэр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн гамшгаас хамгаалах улсын албаны хэрэгжүүлсэн арга хэмжээг салбарын байгууллагуудад зарлан мэдээллэх			2020.02.14- 2020.03.02	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Г.Ганхүү	УУХҮЯ-ны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

18	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах уул уурхай, хүнд үйлдвэрийн улсын албатай холбогдох бэлэн байдлын нөхцлийг хангаж, нэгжийн ангиуд болон холбогдох байгууллагуудад мэдэгдэх. /Холбоо барьсан тохиолдолд бүртгэл хөтлөх/			2020.02.14-2020.03.02	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Г.Ганхүү	УУХҮЯ-ны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
19	Салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах	33.1.6	1 дэх заалт	2020 оны 2 сард	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Г.Ганхүү	УУХҮЯ-ны Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
20	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудтай гамшгаас хамгаалах талаар харилцаа холбоо тогтоож, бүртгэл хөтлөх	33.1.8	ОБЕГ-ын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2019.06.14-ний өдрийн 01 шаардлага	2020.02.14-2020.04.15	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан	Г.Ганхүү	УУХҮЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
21	Салбарын байгууллагуудын эрсдлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд үндэслэн гамшгийн нөөцийг нэмэгдүүлэхэд шаардагдах зардлын төсвийг боловсруулж танилцуулах	33.1.1	9 дэх заалт	2020.04.01	Ар тал, хангалт	М.Аясгалан	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга
22	ОБЕГ-тай хамтран мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг хангах сургалтыг зохион байгуулах	33.1.4	1 дэх заалт	2020 оны 3 сард	Сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан	Ш.Уранчимэг	УУХҮЯ-ны сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн
23	Байгууллагад гаднын хүн нэвтрүүлэхгүй нөхцлийг хангаж, 1 давхарт тусгайлан ариутгасан уулзалтын өрөөг ажиллуулах, төв хаалга болон давхруудын шат бүрт шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг байршуулах		13 дахь заалт	2020.02.14-2020.03.02	Ар тал, хангалт хариуцсан ажилтан	М.Аясгалан	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга
24	Төв хаалга болон давхруудын шат бүрт шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжүүдийг байршуулах		13 дахь заалт	2020.02.14-2020.03.02	Ар тал, хангалт хариуцсан ажилтан	М.Аясгалан	УУХҮЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга

25	Нийслэлийн онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын байцаагчийн албан шаардлагын биелэлтийг хангах арга хэмжээнүүдийг зохион байгуулж, биелэлтийг тайлагнах		2019.11.20-ны өдрийн 13/36 тоот албан шаардлага	2020 оны 3 сард	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан ажилтан	Ш.Эрдэнэцэцэг	УУХҮЯ-ны СХ-ийн ахлах шинжээч
					Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал хариуцсан ажилтан	Н.Амартуул, Б.Отгонбаяр	УУХҮЯ-ны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
26	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг танилцуулах			2020 оны 4 сард		Штабын бүрэлдэхүүн	